



ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль

Хөтөлбөрийн нэр: “Эх барихуй” бакалаврын хөтөлбөр

Индекс: 091308

Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Баярмаа
Гишүүд: Н.Мөнгөнсор
С.Баясгалан

2023.06.08

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

4.1: Оюутнуудын нэрс

4.2: Багш нарын нэрс

4.3: Төгсөгчдийн нэрс.

4.4: Ажил олгогчдын нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

АШУУИС	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
АУС	Анагаах Ухааны Сургууль
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БШУЯ	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
БСШУЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам
БМИҮЗ	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ИСУМС	Их Сургуулийн Удирдлага Мэдээллийн Систем
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ЭМХТ	Эрүүл Мэндийн Хөгжлийн Төв

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	АШУУИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар АУС	
Хөтөлбөрийн нэр	Эх барихуй	
Индекс	091308	
Шинжээчид	<p>Шинжээчийн багийн ахлагч: Д.Баярмаа - Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын Стратеги удирдлагын хэлтсийн Салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, нийгмийн баталгааны асуудал хариуцсан ахлах шинжээч</p> <p>Шинжээчийн багийн гишүүн: Н.Мөнгөсор - Энэрэл дээд сургуулийн сургалтын албаны дарга С.Баясгалан - Хүнлэг” эмэгтэйчүүдийн эмнэлгийн зөвлөх эмч, эх барих эмэгтэйчүүдийн зөвлөх зэргийн эмч, клиникийн профессор</p>	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Б.Мядагмаа – БМИҮЗ-ийн Магадлан итгэмжлэл хариуцсан ахлах шинжээч	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2023.05.29	Шинжээчийн багийн танилцуулга
		Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцах
		Оюутнуудын төлөөлөлтэй уулзах /танхимаар/
		Багш нарын төлөөлөлтэй уулзах /танхимаар/
		Номын сан болон лаборатори, үйлчилгээний хэсэгтэй танилцах
		Өөрийн үнэлгээний тайлангийн нотлох баримттай танилцах
	2023.05.30	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах
		Төгсөгчдийн төлөөлөлтэй уулзах /цахимаар/
		Ажил олгогчийн төлөөлөлтэй уулзах /цахимаар/
		Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах
		Шинжээчдийн баг дүгнэлтээ хэлэлцэж гаргах, нэмэлт материал үзэх, танилцах
Магадлан итгэмжлэлийн урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэх		
2023.06.08	Шинжээчид үнэлгээний тайланг БМИҮЗ-ийн мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.	
	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.	
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 08 дугаар тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

- **Зорилго:** Монгол Улсад эх, нярайн эндэгдлийг бууруулах, хэвийн жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндэтгэлтэй тусламж үзүүлэх, хүндрэлээс сэргийлэх, гэр бүл төлөвлөлтийн хангагдаагүй хэрэгцээг бууруулах, нийгмийн эрүүл мэндийн тусламжийг чанартай хүргэж, тасралтгүй суралцагч, хөрвөх чадвартай мэргэжилтэн бэлтгэнэ.
- **Хөтөлбөрийн зорилтууд:**
 - Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийн загварыг нутагшуулах
 - Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн технологийг боловсронгуй болгох
- **Хөтөлбөрийн төгсөгчийн загвар:** Эх баригч мэргэжилтний цогц чадамжийг 2016 оноос үе шаттай боловсруулсан бөгөөд төгсөгчийн загварыг мэргэжилтний цогц чадамжаар 6 (зөвлөгч, манлайлагч, хамтрагч, харилцагч, тасралтгүй суралцагч, мэргэжилтэн) чиглэлд 68 мэдлэг, 124 чадвар, 33 хандлагаар тодорхойлсон.
- **Сургалтын төлөвлөгөөний бүтэц:** Суралцахуйн үр дүн, хичээл бүрээр эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг тусгасан, хоорондын залгамж, холбоог хангасан, заавал болон сонгон суралцах 80 хичээлийн хөтөлбөрийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны 174 дүгээр тушаалын дагуу боловсруулж, мөрдөж ажилладаг.
- **Багшлах бүрэлдэхүүний нөөц, чадамж:** Хөтөлбөр хэрэгжүүлэхэд мэргэжлийн 5 тэнхимийн 40 багш оролцдог бөгөөд 36 багш 100% үндсэн багшаар ажиллаж, сургалтыг зохион байгуулдаг. Багш нарын 28.8% нь доктор, түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой.
- **Суралцагчдын тоо:** АУС-д 2018-2022 онд нийт 1630 оюутан элссэн суралцсаны 81 (5%) нь “Эх барихуй” хөтөлбөрт элсэгчид байна.
- **Төгсөгчдийн тоо:** 2007 оноос 16 жилийн хугацаанд 972 эх баригч бэлтгэж төгсгөсөн.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар АУС нь Эх барихуйн хөтөлбөрийг 2007 оноос хэрэгжүүлж, 16 жилийн турш хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэн, 972 эх баригч бэлтгэж төгсгөсөн.
- Хөтөлбөрт НҮБ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, ДЭМБ-ын Сувилахуй, эх барихуйн тусламж үйлчилгээний стратеги (2021-2025), Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/216 дугаар тушаалаар баталсан “Эх баригч мэргэжилтний ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт”, 2020 оны А/318 дугаар тушаалаар баталсан “Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээний журам”, 2020 оны А/364 дугаар тушаалаар баталсан “Охидод эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар”, 2021 оны А/760 дугаар тушаалаар баталсан “Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө” зэрэг эрх зүйн баримтуудыг тусгасан.
- ЭМЯ-ны харьяа ЭМХТ-өөс гаргасан “2022 оны Эрүүл мэндийн үзүүлэлт”-ээр Монгол Улсын хүн амд нийт 1127 эх баригч мэргэжилтэн эх барихуйн тусламж, үйлчилгээ үзүүлж байна. Хүн амын өсөлт нэмэгдэж байгаатай холбоотой эх баригчийн ажлын ачаалал ихэссэн бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн А/115 дугаар тогтоолоор “Эх баригч” мэргэжил нь дээд боловсролын эрэлттэй мэргэжлийн чиглэлд багтсан.
- Эх баригч мэргэжлийн хөдөлмөрийн зах зээлд эрэлт, хэрэгцээг зөв тодорхойлсон. Судалгаа нь үндэслэлтэй. Оролцогч талуудын саналаас харахад эх баригч мэргэжилтний эрэлт болон тус сургуулийн төгсгөн гаргаж буй мэргэжилтний нийлүүлэлт зохистой харьцаанд байна гэж үзэхээр байна.
- Франц Улсын Клермонт Феррандын Эх барихуйн сургуультай хамтын ажиллагаатай бөгөөд сургалтын хөтөлбөрийн талаар туршлага судалж, сургалтын төлөвлөгөөг 2018 онд шинэчилсэн. Тус сургууль нь эх баригчийг төгсөлтийн өмнөх сургалтаар (5 жил-235 багц цаг, магистр зэрэг) төгсгөж байгаагаас 108 багц цаг дутуу, бакалавр зэрэгтэй төгсгөж байна.
- АНУ-ын Колумбын их сургуулийн Сувилахуйн сургууль (4.5 жил-176 багц цаг) , Япон Улсын Сувилахуйн үндэсний коллеж (4 жил-128 багц цаг) бэлтгэж байгаагаас Японы Сувилахуйн үндэсний коллежийн хөтөлбөртэй багц цагийн хувьд ойролцоо, харин Энэрэл дээд сургуулийн эх баригчийн бакалаврын хөтөлбөртэй харьцуулж үзэхэд нийтлэг тавигдах стандарт шаардлагыг хангасан байдал нь ижил боловч судлах хичээлийн тоо 23 илүү, 6 багц цаг дутуу байсан.

Онцлог зүйл:

- Эх баригч мэргэжилтний цогц чадамжийг боловсруулсан.
- Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийг үндэсний, олон улсын чиг хандлага, нийгмийн эрэлт хэрэгцээ, оролцогч талуудын саналыг тусгаж, зохих дүрэм, журамд нийцүүлэн боловсруулж, тасралтгүй сайжруулах тогтолцоо бүрдүүлсэн.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Алсын харааг “Дэлхийн жишигт нийцсэн чадварлаг мэргэжилтэнг бид бэлтгэнэ”, эрхэм зорилгыг “Олон улсын стандартад нийцсэн чанартай боловсрол, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг нээлттэй сургууль байхад оршино” гэж тодорхойлсон.
- Эх баригч мэргэжилтний цогц чадамж боловсруулсан, гарын авлагатай.
- Хөтөлбөрийн зорилгыг “Монгол Улсад эх, нярайн эндэгдлийг бууруулах, хэвийн жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндэтгэлтэй тусламж үзүүлэх, хүндрэлээс сэргийлэх, гэр бүл төлөвлөлтийн хангагдаагүй хэрэгцээг бууруулах, нийгмийн эрүүл мэндийн тусламжийг чанартай хүргэж, тасралтгүй суралцагч, хөрвөх чадвартай мэргэжилтэн бэлтгэнэ” гэж тодорхойлсон.
- Хөтөлбөрийн зорилт, агуулга, чиглэлийг оролцогч талуудын хэрэгцээ, мэргэжилтний ур чадварын шалгуур, үзүүлэлтийг үндэслэн тодорхойлсон.
- Нэгж хичээлээр олж авах чадамж, хөтөлбөрөөр олж авах чадамж зэрэг хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн хамаарлыг харуулсан.

Онцлог зүйл:

- Төгсөгчийн загварыг мэргэжилтний цогц чадамжаар 6 (зөвлөгч, манлайлагч, хамтрагч, харилцагч, тасралтгүй суралцагч, мэргэжилтэн) чиглэлд 68 мэдлэг, 124 чадвар, 33 хандлагаар тодорхойлсон.
- Эх баригч мэргэжилтний цогц чадамжийг боловсруулах судалгаанд 464 суралцагч, 108 багш, 211 эх баригч хамруулсан.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын төлөвлөгөөг АУС-ийн захирлын 2021 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн А/43 дугаар тушаалаар баталсан.
- Хөтөлбөрийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/174 дүгээр тушаалаар баталсан “Сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ын дагуу боловсруулсан.
- АУС-ийн захирлын 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/81 дүгээр тушаалаар Хөтөлбөрийн дэд хороог байгуулсан ба хамгийн сүүлд захирлын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/87 дугаар тушаалаар Хөтөлбөрийн дэд хорооны үйл ажиллагааг зохицуулах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.
- 2021-2022 оны хичээлийн жилд ажил олгогч, төгсөгчдийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, хөтөлбөрийн танилцуулга хийж, сэтгэл ханамжийн судалгаа авч боловсруулсан.

Онцлог зүйл:

- АУС-ийн захирлын 2022 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн А/10 дугаар тушаалаар дэд хороог шинэчлэхэд ажил олгогч байгууллагыг төлөөлж 5 аймгийн нэгдсэн эмнэлэг, төгсөгчдийн төлөөлөл орсон ба захирлын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/87 дугаар тушаалаар шинэчлэн баталсан дэд хороо оюутны төлөөлөл орсон.
- Хөтөлбөрийн дэд хороо нь сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийх, хөтөлбөрийн боловсролыг зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүнд үнэлэлт, дүгнэлтийг гаргадаг бөгөөд хөтөлбөрийн сайжруулалтад тусгах үйл ажиллагааг мэргэжлийн тэнхим, багш нар зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Сургалтын дуураймал орчин, тоног төхөөрөмжийг сайжруулах.

Зөвлөмж:

- Сургалтын хэрэглэгдэхүүний шинэчлэлийг технологийн хурдацтай зэрэгцүүлэн хийж ур чадварын төвийг өргөжүүлэх;
- Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг судлах.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Эх барихуйн бакалаврын хөтөлбөрийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/174 дүгээр тушаалаар баталсан “Дээд боловсролын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ын дагуу боловсруулсан. АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь АУ-ны сургуулийн захирлын 2018 оны 03 сарын 09 өдрийн А/09 дүгээр тушаалаар хөтөлбөрийн дэд хороо байгуулагдаж, 2010, 2014, 2016, 2018 онуудад хөтөлбөрийн шинэчлэл, сайжруулалтыг хийж хөтөлбөрийн дэд хороогоор 4 удаа хэлэлцүүлсэн.
- Эх барихуйн бакалаврын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх хүрээнд 2021 оноос эхлэн нийт 5 удаа явцын хэлэлцүүлэг зохион байгуулсан. Үүнд: Анагаах ухааны сургуулийн Хөтөлбөрийн дэд хорооны хурлаар 3 удаа, Захиргааны зөвлөлийн хурлаар 2 удаа танилцуулж, санал авч, тусгасан байна.
- Хөтөлбөрийн төгсгөлд хүрэх үр дүнг суралцагч, төгсөгч, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээр үнэлдэг.
- Эх барихуйн сургалтын төлөвлөгөө нь 73 хичээлийн 127 багц цагийн багтаамжтай, бүтцийн ерөнхий суурь хичээл 20.8%, мэргэжлийн суурь 25%, мэргэшүүлэх хичээл 54.2% байгаа нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/174 дүгээр тушаалаар баталсан “Дээд боловсролын хөтөлбөрт

тавигдах нийтлэг шаардлага"-ын 2.2.1 дэх заалтад тусгасан шаардлагыг хангасан.

- Сургалтын гэрээт 11 эрүүл мэндийн байгууллагад эрүүл эх барихын төрөх тасагтай танилцах, эрүүл жирэмсэн үеийн эх баригчийн тусламж, хэвийн төрөлтийн үеийн эх баригчийн тусламж, эх баригчийн мэргэших 10 багц цагийн дадлагыг батлагдсан сургалтын төлөвлөгөө, дадлагын удирдамжийн дагуу чиглүүлэгч эх баригч, сувилахуйн албаны арга зүйч мэргэжилтнүүд эмнэл зүй дадлагыг удирдаж ажилладаг.
- Хөтөлбөрийн хүрэх үр дүн (PLO) эх баригч мэргэжилтний цогц чадамжид харгалзах хичээлүүдийн хөтөлбөрийн үр дүн (CLO) мэдлэг, чадвар, хандлагад тусгаж, уялдаа холбоог ханган хэрэгжүүлдэг.
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/348 дугаар тушаалын дагуу суралцагчийн ачаалал цагийг тооцож, хичээлийн хуваарийг ИСУМС-д оруулдаг.

Онцлог зүйл

- Эх барихуйн хөтөлбөрөөр суралцагчдад 68 мэдлэг, 124 ур чадвар, 33 хандлагыг агуулгын давхцалгүй, хичээлийн уялдаа холбоотойгоор цогц чадамжийг олгодог.

Анхаарах асуудал:

- Ерөнхий суурийн зарим хичээлийн хөтөлбөрт хувь хүний хөгжлийн агуулга сэдвийг оруулах;
- Сургуулийн хэмжээнд суралцаж байгаа эх барихуйн хөтөлбөрөөр суралцагчдын зөөлөн ур чадварыг тодорхойлон, шаардлагатай ур чадварыг олгоход анхаарч ажиллах.

Зөвлөмж:

- Сургалтын төлөвлөгөөнд англи хэлний хичээлийн багц цагийг нэмэгдүүлэх, англи хэлийг давтамжтайгаар тасралтгүй суралцах сургалтыг зохион байгуулах;
- Ажил олгогч байгууллага, төгсөгчдөөс зөөлөн ур чадварыг тодруулсан асуумж судалгааг авах.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ын захирлын 2021 оны А/19 дүгээр тушаалын 2 хавсралтаар баталсан "Сургалтын технологи, чанарын хяналтын журам"-ыг хэрэгжүүлдэг. Эх барихуйн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ танхимын, бие даасан, цахим сургалт, холимог сургалтыг зохион байгуулдаг.
- Эмнэл зүйн тэнхимийн багш нар суралцагчийн хэв маяг, онцлог байдлыг харгалзан шинэлэг арга, арга зүйг нэвтрүүлж, эмнэл зүйн сургалтанд SCORPIO аргыг хэрэглэдэг.
- Багш нарын хамгийн түгээмэл хэрэглэдэг 26 аргаас хамгийн олон давтамж бүхий аргуудад жижиг бүлгээр ажиллах арга, тархины шуурга буюу асуулт хариулт нэг үгээр арга, бүлгийн PPT хэлэлцүүлгийн арга, шууд арга, тохиолдолд суурилсан арга, орны дэргэдэх сургалтын арга, асуудалд суурилсан аргуудыг олон давтамжтай ашигладаг.

- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/146 дугаар тушаал, АШУҮИС-ийн захирлын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/249 дүгээр тушаалыг тус тус үндэслэн хичээл, сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах удирдамжийн дагуу elearning.edu.mn, google classroom, google meet цахим системийг ашиглан сургалтыг зохион байгуулдаг.
- 2022-2023 онд erdem.edu.mn сургалтын программд 23 хичээлийн 2076 сорил, elearning.mn сургалтын программд 2019-2023 онд нийт 71 төрлийн 506 цахим хичээлийг байршуулж, сургалтыг зохион байгуулсан. Суралцагчдын хандалтын тоо 27830 байгаа нь оюутнууд үр дүнтэй цахимаар суралцах боломж олгож байгааг харуулж байна.
- Эх барихуйн мэргэжлийн ур чадвар олгох зорилготой гардан үйлдлийн видео бичлэг боловсруулж, сургалтанд ашигладаг. Үүнд:
 - ✓ Эх барих хичээлийн-багш бэлтгэн боловсруулсан-32, оюутан бие даан хийсэн-250;
 - ✓ Дотор-1,2 хичээлийн багш хийсэн-16, оюутан бие даан хийсэн-25;
 - ✓ Хүүхэд, нярайн хичээлийн багш хийсэн-21;
 - ✓ Мэс засал, гэмтэл, яаралтай тусламжийн хичээлийн багш хийсэн- 79, оюутан хийсэн-275.

Онцлог зүйл:

- “Загварчлалын аргаар мэдлэг бүтээх” арга зүйг эх барихуйн хөтөлбөрт зориулж боловсруулсан.
- Эх барихуйн хоёрол, гурвал, дөрвөл, тавтыг оношилгоонд ашиглах загвар боловсруулж, төгсөлтийн өмнөх болон дараах сургалтад ашиглаж байна. (Оношилгоонд хэрэглэгддэг стандарт удирдамжууд, гурвал гэдэг нь оношилгоо, үнэлгээ, хяналтанд хэрэглэгддэг. жишээ: төрөлтийн 3 дугаар үе, дутуу нярайн жин, ургийн толгойн гэдийлтийн зэрэг, хязангийн урагдлын эмнэл зүй гэх мэт)
- Эх барихуйн сургалтад дараах аргыг мэргэжлийн онцлогт тохируулан гар дор ашиглах материал хэрэглэгдэхүүн боловсруулж ашигладаг:
 - ✓ WARK загварыг ашиглаж үнэлгээ өгөх сургалтын аргыг зөв сонгох;
 - ✓ Асуудлын мод буюу оюуны зураглал хийх;
 - ✓ Эвлүүлгийн арга: жирэмсэн үеийн хэвлийн өвдөлт бүхий эмгэгүүдийг ялган оношилгоонд хэрэглэдэг;
 - ✓ Бингий арга: ур чадварын пирамид бүтээх арга;
 - ✓ Зөөлөн чадварын мод төлөвшүүлэх сургалтад зориулан хэрэглэдэг;
 - ✓ Түргэн сэтгэх арга: yes, no аргыг сэтгэн бодох, шийдвэр гаргах зорилгоор хэрэглэдэг.

Анхаарах асуудал:

- Суралцагчид мэдлэг, ур, чадвар, хандлага олгоход сургалтын онцлог аргыг илүү үр дүнтэй ашиглахад анхаарах.

Зөвлөмж:

- Эх барихуйн мэргэшүүлэх хичээлд давтамжтай хэрэглэдэг онцлог сургалтын аргуудыг суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагатай харьцуулсан судалгааг хийж хөтөлбөрийн төгсгөлд хүрэх үр дүнг тооцдог байх.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн “Суралцагчийг үнэлэх журам, сургалтын технологи, чанар хяналтын үлгэрчилсэн журам”-аар зохицуулагддаг.
- Онолын шалгалтыг олон хувилбарт сорил, E сорил ашиглан үнэлдэг. Ур чадварыг төлөвлөгдсөн зорилготой гардан шалгалт, өртөөчилсөн, урт болон богино хэлбэрийн тодорхой хугацаанд эмнэлзүйн мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлдэг.
- АШУҮИС-ийн захирлын 2022 оны А/125 дугаар тушаалын төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын үнэлгээний аргачлалыг мөрддөг.
- Төгсөлтийн шалгалтын зөвлөл төгсөлтийн шалгалтыг зохион байгуулдаг багөөд төгсөгчдийн цогц чадамж (мэдлэг, чадвар, хандлага)-ийн түвшинг үнэлдэг.
- Сургалтын алба нь хичээлийн жил бүр суралцагчдын сурлагын амжилт, чанарт анализ хийдэг.

Онцлог зүйл:

- Эх барихуйн мэргэжлийн дадлагын хичээлийн портфайл хавтас боловсруулж, эмнэлзүйн сургалтад Миллерийн үнэлгээний аргыг нэвтрүүлсэн ба оюутан 5 түвшинд өөрийгөө үнэлдэг.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- АУС нь 1500 оюутны багтаамжтай хичээлийн 2 байр, 150 суудалтай номын сан (2 танхимтай), 300 оюутан амьдрах дотуур байртай, хичээлийн 4 заал, сургалтын 6 лаборатори, ур чадварын 3 танхим, дадлага хичээлийн 27 анги, эрдмийн өргөө, урлаг спортын танхим, “Сайхан сэтгэл” эмнэлэг, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөөтэй, Дархан-Анагаах амралт, сувилалтай.
- АУС-ийн эзэмшил газрын 80 хувиас доошгүйг зүлэгжүүлж, хатуу хучилтаар хучсан нь тоос, сул шороо босох, агаар дуслын халдварын тархалтыг бууруулахад хувь нэмэр оруулж байна.
- Нэг оюутанд ногдох сургалтын талбайн хүрэлцээ сайн. Нэг оюутанд ноогдох талбай 2,8 м², норматив нь 2,2 м².
- АУС-ийн "Сайхан сэтгэл" клиник эмнэлэгт байрлах эмэгтэйчүүдийн кабинет 2014 оноос Дархан-Уул аймгийн их, дээд мэргэжлийн сургуулийн оюутнууд болон иргэдэд гэр бүл төлөвлөлт, эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө

өгдөг. 2023 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс оюутны байр болон клиник эмнэлгийг засварт оруулсан байна.

- Оюутнуудын чөлөөт цагаараа цахим мэдээллийг авах, өөрийгөө хөгжүүлэх, бие даан суралцахад зориулж 46 компьютер бүхий интернэт кафе ажиллуулдаг.
- Оюутан ээжид зориулсан хүүхэд хөхүүлэх өрөөг тохижуулж шинээр байгуулсан.
- Улсын төсвөөс спортын заал 1,3 тэрбум төгрөгөөр шинээр барих, оюутны байрыг 700 сая төгрөгөөр засварлах ажлыг хийж 2023 оны 9 сард ашиглалтад оруулахаар ажиллаж байна.
- Сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, муляж, сургалтын цомог зэрэгт 250.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.
- Эх барихуйн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлийн дадлага, лабораторийн хичээлд ашиглах багаж, тоног төхөөрөмж, урвалж бодисын хангамж, ур чадварын төвийн тоног төхөөрөмжийн хангалтыг жил бүр тодорхой төсөв зарцуулан сайжруулдаг.
- Багш нарт цахимаар болон танхимаар хичээл заах ажлын орчин бүрдүүлсэн. Багш нарт цахим хичээл бэлтгэх 2 өрөөг тоног төхөөрөмжийн хамт тохижуулж, үйл ажиллагаандаа ашиглаж байна. 2022 онд багш нарын хичээлийн чанар, стандартыг сайжруулахын тулд цахим хичээл, контентын өрөөнд 1.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч суурилуулсан.
- Сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих үүднээс эмнэлзүйн кабинетад 10 компьютер, дотрын кабинетад 10 компьютер байрлуулж сургалт, судалгааны ажилд ашигладаг.

Онцлог зүйл:

- Сургууль 2018 оноос байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001:2015 стандартыг хэрэгжүүлсэн.
- Байгууллагын дотор болон гадна талбайд бүрэн цэцэрлэгжүүлэлт хийж, таатай орчин бүрдүүлсэн.
- Оюутан ээжид зориулсан Хүүхэд хөхүүлэх өрөөг байгуулж, ашигладаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Эх барихуйн хөтөлбөрөөр суралцагч оюутнуудад шаардагдах тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн, муляж хүрэлцээтэй.
- Сүүлийн 5 жилийн хугацаанд 53 нэр төрлийн сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авахад 250.7 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Эмнэл зүйн ур чадварын өрөө (стандарт төрөх өрөө, гэр бүл төлөвлөлт, эмэгтэйчүүдийн зөвлөгөө өгөх кабинет)-г 2017 шинэчлэн тохижуулж, эмнэлзүйн дадлагын хичээлийг тогтмол явуулж байна. Эх баригч мэргэжлээр суралцаж буй 2-4 дугаар дамжааны оюутнууд энгийн төрөлтийн симулятор, ургийн зүрхний цохилт чагнах симулятор, эмэгтэйчүүдийн үзлэгийн, жирэмсэн, төрөх, төрсний дараах үзлэгийн болон нярайн анхны тусламж үзүүлэх муляж зэрэг нийт 10 гаруй нэр төрлийн симуляторууд, муляж дээр дадлагажиж, ур чадварт суралцаж байна.

Онцлог зүйл:

- Эмнэл зүйн сургалтын танхимууд хүрэлцээтэй, талбай хангалттай.

Анхаарах асуудал:

- Төрөлтийн симуляторийг шинэчлэх.

Зөвлөмж:

- Сүүлийн үеийн төрөлтийн симуляторыг худалдаж авах талаар бичсэн төслөө идэвхжүүлж, хэрэгжүүлэх.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн номын сан нь хичээлийн А байранд 130 хүний суудалтай уншлагын танхимтай, окутны байранд 54 уншигчийн суудалтай уншлагын танхимтай, тус танхимыг 24 цагаар ажиллуулдаг.
- Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага MNS 5742:2007 стандартад тусгагдсаны дагуу номын төрөл анги, үсэг дарааллын цаасан каталог, номын сангийн LIB4U PC Version болон Коха програмуудыг ашигладаг.
- Төгсөгчдийн санхүүжилтээр багаар ажиллах 2 өрөөг уншлагын танхимын дэргэд тохижуулсан.
- АШУУИС-ийн бүх салбар сургуульд хамаардаг цахим номын сангийн бүрдүүлэлтэд монгол хэл дээрх ховор сурах бичгийг сканердаж, цахим хэлбэрт хөрвүүлж <https://fliphtml5.com> цахим санд оруулдаг.
- Судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлийг цахим хувилбараар <https://fliphtml5.com>, <https://mnums-da.edu.mn/post/110>, www.mongolmed.mn цахим санд байршуулан ажиллаж байна.
- Эх барихуйн мэргэжлийн сурах бичиг 115 нэр төрлийн 1905 ширхэг байна. Тэдгээрийг хэлээр нь ангилбал монгол хэлээр 805, англи хэлээр 102, орос хэлээр 218 ширхэг байна. Суурь хичээлийн 690 нэр төрлийн 7638 сурах бичиг байна.
- Хамгийн их эрэлттэй сурах бичиг нь Эх барих судлалын тэнхимээс 2015 онд гаргасан “Эх барих” сурах бичиг байна.
- 2023 онд 10 төрлийн 261 ширхэг мэргэжлийн номыг 14,660.000 төгрөгөөр худалдан авч баяжуулсан.
- Эх барихуйн сурах бичгийн 10 хувь нь цахимд орсон байна.

Онцлог зүйл:

- Шинэ ном сурах бичгээр хангах ажил сайн хийгддэг.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн захирлын 2022 оны А/225 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг зохицуулах журам”, АУС-ийн захирлын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/87 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Хөтөлбөрийн дэд хорооны үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хэрэгжүүлж ажилладаг.
- Эх барихуйн бакалаврын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх хүрээнд зохион байгуулсан Анагаах ухааны сургуулийн Хөтөлбөрийн дэд хорооны 3 удаагийн хурал, Захиргааны зөвлөлийн 2 удаагийн хурлын тэмдэглэл хөтөлсөн.
- 2017-2018 онд Эх барихуйн сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, Эх баригч мэргэжилтний цогц чадамж, 2018-2019 онд Сувилахуйн хөтөлбөрийн шинэчлэл, 2019-2020 онд ХНХЯ-аас баталсан чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагын хүрээнд Уламжлалт анагаахын сувилагчийн хөтөлбөрийн шинэчлэл, 2020-2021 онд Уламжлалт анагаахын сувилагчийн сургалтын хөтөлбөр БШУЯ-д шилжсэнтэй холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 174 дүгээр тушаалын шаардлагын хүрээнд боловсруулсан хичээлийн хөтөлбөрийн шинэчлэл, 2021-2022 онд Сувилахуйн бакалавр, дипломын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, 2022-2023 онд Эх барихуй, Эм найруулагчийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн талаар хэлэлцэж, дүн шинжилгээ хийж ажилласан.
- Оюутны зөвлөл санал, гомдлыг шийдвэрлэхэд тэнхим, захирлын зөвлөлтэй хамтран ажилладаг. Оюутны зөвлөлөөс жил бүрийн 11 дүгээр сарын 17-ны өдөр “Оюутны эрхийг хамгаалах өдөр”-ийг тэмдэглэж, нээлттэй хэлэлцүүлэг хийж, санал, гомдлыг нэгтгэж, сургуулийн удирдлага, багш нарт уламжилж, шийдвэрлүүлж, эргэн тайлагнадаг.
- 2017-2022 онд нийт 317 санал, гомдол, хүсэлт ирснээс 60.9% нь цахимаар ирүүлсэн байна. Ирүүлсэн санал, гомдол, хүсэлтийн 29.2% нь ИСУМС, цахим хичээл судлахтай холбоотой, 23.4% нь сургалтын төлбөрийн төлөлттэй холбоотой санал, хүсэлт байсан.
- АШУҮИС-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “АШУҮИС-ийн хөгжлийн бодлого” болон “АУС-ийг хөгжүүлэх Стратеги төлөвлөгөө-2030” бодлогын баримт бичгийг баримтлан ажилладаг.
- Хөгжлийн стратеги төлөвлөгөөний зорилтыг 2030 он хүртэл 5 чиглэлээр тодорхойлж, дунд ба урт хугацааны төлөвлөлтийг хийж, хэрэгжүүлж байна.
- АШУҮИС-ийн захирлын 2022 оны 02 дугаар сарын 16-ны А/25 дугаар тушаалаар баталсан “Багшийн алтан дүрэм”, 2021 оны 5 дугаар сарын 13-ны А/103 дугаар тушаалаар баталсан “Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам”, 2021 оны 12 дугаар сарын 22-ны А/259 дугаар тушаалаар баталсан “Багшийн хөгжлийн хөтөлбөр”, АУС-ийн захирлын 2022 оны 3 дугаар сарын 02-ны А/09 дүгээр тушаалаар баталсан “Багшийн хөгжлийн дэд хөтөлбөр – 2022-2024 он”-ийг тус тус хэрэгжүүлж байна.
- Хичээлийн жилийн эхэнд сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааг тусгасан “Сургалт, хүмүүжлийн ажлын нэгдсэн төлөвлөгөө”-г боловсруулж, АУС-ийн захирлын зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулдаг.

- Хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж хэвшсэн. Жил бүр үйл ажиллагааны төлөвлөлтийг хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн, тоо, чанар, хугацаа гэсэн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр боловсруулж, хэрэгжүүлдэг ба төлөвлөлтийн гүйцэтгэлийг жилд 2 удаа хамт олон ил тод, нээлттэй танилцуулж, дүгнэдэг. Тайлангийн гүйцэтгэлээр оны төгсгөлд урамшуулдаг.
- АУС-ийн захирлын 2021 оны А/89 дүгээр тушаалаар баталсан “АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар АУС-ийн Удирдлага, мэдээллийн системтэй ажиллах журам”-ыг мөрдөж ажилладаг.
- ИСУМС-ийг 2018 онд 880 оюутан ашиглаж байсан бол 2022 онд 970 оюутан ашигласан байна. Элсэгчдийн дэлгэрэнгүй бүртгэл, дахин судлах, дахин шалгалтын дүн, хөтөлбөрийн хүрээнд оюутан, багш нэг бүртэй холбосон хичээлийн тоо, оюутантай холбосон сонголт хичээлийн тоо, төгсөлтийн дүн тулгалт, дипломын хавсралт, мэргэжлийн үнэмлэхний хэвлэлт зэрэг үзүүлэлтээр сүүлийн 5 жилийн ашиглалт, хяналт, ил тод байдалд дүн шинжилгээ хийсэн.
- ИСУМС-ийн ашиглалт, шинэчлэлийн талаар багш, оюутнуудад тухай бүр мэдээлж, мэргэжил арга зүйгээр тогтмол хангаж ажилладаг.

Онцлог зүйл:

- Хөгжлийн стратеги төлөвлөгөөний зорилтыг 2030 он хүртэл чадварлаг, мэргэшсэн хүний нөөц, чанартай боловсрол, эрдэм шинжилгээ, судалгааны орчин, их сургуулийн эмнэлгийн тогтолцоо, мэдээлэл технологи, гадаад харилцаа гэсэн 5 чиглэлээр тодорхойлж, 2020, 2023, 2025, 2030 онд хүрэх үр дүнг тодорхойлон хэрэгжүүлж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Гадаад хамтын ажиллагааны гэрээг дотоод, гадаадын 15 байгууллагатай 1-10 жилийн хугацаатай байгуулан ажиллаж байна: Франц Улсын Мулан хотын Сувилахуйн сургууль, Клермонт Феррандын Эх барихуйн сургууль, Япон Улсын Жичи АУС-ийн Сувилахуйн сургууль, ОХУ-ын Башкирын АУИС, Тайланд Улсын Чангмай Их сургуулийн Сувилахуйн Факультет, БНСУ-ын Самюк Эрүүл мэндийн их сургууль, Турк Улсын Эгэ Их сургууль, БНХАУ-ын Нанжин АУС, Олон улсын хүний нөөцийн солилцооны байгууллага, Гэйтвэй карьер консалтинг компани, Английн Elsevier LTD компани гэх мэт.
- 2018-2022 онд 10 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж ажилласан байна:
 - ✓ Европын Холбооны Эразмус+ хөтөлбөрийн хүрээнд Францын Мулан хотын Сувилахуйн сургуультай багш, оюутан солилцооны хамтарсан хөтөлбөр;
 - ✓ Япон Улсын Мацүда сургуультай “Япон Улсад суралцах, мэргэжлээрээ ажиллах боломж” төсөл;
 - ✓ Япон Улсын Токиогийн Их сургууль, Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэгтэй хамтарсан “Дархан-Уул аймаг дахь жирэмсэн эмэгтэйчүүдийн тамхидалт, дам тамхидалтын төрөх үеийн үр дагаврыг тандах судалгаа” төсөлт ажил;
 - ✓ БШУЯ, Дээд боловсролын шинэчлэл төсөл, Азийн Хөгжлийн Банкны дэмжлэгтэйгээр “Хүн бүрд хүртээмжтэй орчин” төсөл;

- ✓ “10 оюутан-10 хөгжлийн бэрхшээлтэй оюутан” төсөл;
 - ✓ Дархан-Уул аймгийн Боловсрол, соёл, урлагийн газартай хамтарсан “Дархан-Уул аймаг дахь ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын тамхидалт, дам тамхидалтын тархалтын судалгаа”;
 - ✓ Япон Улсын Жичигийн АУС-ийн Сувилахуйн сургуультай хамтарсан “Япон болон Монгол Улс дахь ахмад настнуудын эрүүл мэндтэй холбоотой амьдралын чанар, түүнд нөлөөлөх хүчин зүйлс” төсөл;
 - ✓ “Эмийн ургамлын полигоныг хөгжүүлэх” төсөл;
 - ✓ Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр “Дархан АУС-ийн оюутнуудад зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд оролцох зөв зан үйлийг төлөвшүүлэх” төсөл.
- Япон Улсаас 2 багш, 8 оюутан 2019 онд ирж, хамтарсан дадлага, жижиг бүлгийн сургалт, уулзалт, хэлэлцүүлэг хийсэн.
 - 2010 оноос хойш багш, оюутан солилцооны хөтөлбөрийн хүрээнд 14 багш, 8 оюутан Франц Улсад очиж суралцсан.
 - АНУ-аас англи хэлний 2 багш гэрээгээр урт хугацаагаар ажиллаж байна.
 - “Дархан-Анагаах” төгсөгчдийн холбоо - гишүүдэд үйлчлэх төрийн бус байгууллага нь 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр байгуулагдсан байна. “Дархан-Анагаах төгсөгчдийн холбоо” фэйсбүүкийн хуудастай, тогтмол үйл ажиллагаатай.
 - Дархан-Анагаах төгсөгчдийн холбоо нь жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлж байгаа бөгөөд төгсөгчдийн дунд “Сайхан сэтгэл” уулзалт жил бүр зохион байгуулж, төгсөгчдийн тухай “Сайхан сэтгэл” ном гаргах, төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа гаргах, хаалттай болон нээлттэй цахим хаяг ажиллуулах, амжилттай ажиллаж байгаа төгсөгчдийг алдаршуулах, “Дарханы Анагаахын бахархал” цуврал танилцуулга гаргах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Төгсөгчдийн тухай “Сайхан сэтгэл” номыг 2015-2019 онд хэвлэмэл байдлаар, 2020-2022 онд цахим байдлаар гаргаж, олон нийтийн хүртээл болгосон.
 - 2018-2022 онд 9 удаагийн төгсөлтийн дараах багц цагийн сургалтад давхардсан тоогоор 756 төгсөгчийг хамруулсан байна:
 - ✓ Төрөлтийн үеийн эх барихуйн тусламж – 60 төгсөгч;
 - ✓ Жирэмсэн, төрөлт, төрсний дараах үеийн нэн шаардлагатай тусламж – 269 төгсөгч;
 - ✓ Эмнэлгийн мэргэжилтний харилцааны соёл, эрх зүйн орчин – 100 төгсөгч гэх мэт.

Онцлог зүйл:

- Хамтарч ажилладаг байгууллага, гадаадын их, дээд сургууль олон, хамтын үйл ажиллагаа тогтвортой.
- Төгсөгчдөд чиглэсэн үйл ажиллагаа, уулзалт жил бүр зохион байгуулж хэвшсэн.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын төлбөрийн орлого, багц цагийн сургалтын орлого, мэргэжил дээшлүүлэх сургалтын орлого, түрээсийн орлого, оюутны дотуур байрны орлого,

хичээл нөхөлтийн орлого, эмнэлгийн орлого зэрэг үйл ажиллагаанаас санхүүжилт бүрдүүлдэг.

- Сургуулийн жилийн төсвийг боловсруулахдаа захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, орлого, зарлагыг тухайн жилийн санхүүжилтийн дагуу төсөвлөдөг. Нийт зардлын төлөвлөгөөний сүүлийн 5 жилийн дундаж нь 2,416 сая төгрөг байна.
- Орлогын төлөвлөгөөний биелэлт 80 орчим байгаа нь сургалтын төлбөрийн орлого төлөвлөсөнд хүрэхгүй байгаатай холбоотой гэж тайлбар өгсөн. Төсвийн гүйцэтгэлийн үнэлгээнээс харахад жил бүр 200-300 сая гаруй төгрөгийн хэмнэлт хийсэн байна.
- Нэг суралцагчид ногдох өртөг зардлын тооцоог жил тутам хийж хэвшсэн. Оюутны тоо буурахад нэг суралцагчийн өртөг нэмэгддэг бөгөөд 2018 онд АУС-д нийт 747 оюутан суралцаж, нэг суралцагчид ногдох өртөг зардал 2.57 сая, 2019 онд 749 оюутан, өртөг зардал 3.2 сая, 2020 онд 711 оюутан, өртөг зардал 2.93 сая болж нэмэгдэж байсан бол 2021, 2022 онд оюутны тоо нэмэгдснээр нэг суралцагчид ногдох өртөг зардал буурсан байна. Тухайлбал 2021 онд 928 оюутан, өртөг зардал 2.47 сая төгрөг, 2022 онд 996 оюутан, өртөг зардал 2.55 сая төгрөг болсон байна.
- Удирдах зөвлөлийн шийдвэрээр сургалтын төлбөрийг жил бүр шинэчлэн тогтоодог бөгөөд инфляцтай уялдуулан нэгдүгээр дамжааны төлбөрийг тодорхой хувиар нэмэгдүүлж тооцдог.
- Сургалтын төлбөрийн орлогын 80-90% нь хөтөлбөрийн шууд санхүүжилтэд зарцуулагддаг. Үүнээс багш, ажиллагсдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд 60-65%, хичээл практик, эрдэм шинжилгээний зардалд 10-16%, хичээлийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 4 хувь зарцуулдаг.
- БШУЯ-ны Боловсролын зээлийн сангаас олгодог буцалтгүй тусламж, оюутны хөгжлийн зээл, тэтгэлэгт жил бүр оюутнуудыг хамруулж, 2018-2022 онд нийт 1,973 сая төгрөгийн санхүүжилт авсан. 2022 оноос орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн их, дээд сургуулийн үндсэн хөтөлбөрт суралцагчдад олгож эхэлсэн сургалтын төлбөрийн 50% тэтгэлэгт нийт 369 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.
- Сургуулийн төсөвт жил бүр хөрөнгө оруулалтын төсөв тусгаж хэрэгжүүлж хэвшсэн.
- ЭКО номын сан барих төсвийг 2019 оны төсөвт тусгаж, хичээлийн байрны өргөтгөлийн барилгыг 234.2 сая төгрөгийн өөрийн хөрөнгийн санхүүжилтээр байгуулсан.
- Сургуулийн эмнэлэг барих бэлтгэл ажлыг хангаж, эмнэлгийн зориулалттай 852 м2 газрын зөвшөөрлийг орон нутгийн захиргаанаас авч, Дархан-Уул аймгийн газар төлөвлөлтийн ерөнхий зураглалд оруулсан ба эмнэлгийн зураг төслийг хийсэн
- Спорт заал барих ажлын тендер зарлаж, шалгарсан компанитай гэрээ байгуулж, барилгын суурь тавих ажлыг 2022 онд гүйцэтгүүлсэн. Нийт төсөвт өртөг 1,275 сая төгрөг бөгөөд 2023 оны төсөвт санхүүжилт бүрэн тусгагдсан. 2023 онд багтаан спорт заалыг ашиглалтад оруулахаар ажиллаж байна.
- Оюутны дотуур байрны их засварын ажлын тендер зарлаж, шалгарсан компанитай гэрээ байгуулж, сантехникийн урсгал засварын ажлыг эхлүүлсэн. Нийт төсөвт өртөг 699, 99 сая төгрөг бөгөөд 2023 оны төсөвт санхүүжилт бүрэн тусгагдсан. 2023 оны 9 дүгээр сард багтаан оюутны байрны их засварыг дуусгахаар ажиллаж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Дархан-Анагаах төгсөгчдийн холбоогоор дамжуулж, төгсөгчдийн мөшгих судалгаа, бусад судалгааг тогтмол хийж, үр дүнг сургалтын хөтөлбөрийн үйл ажиллагаанд тусгаж хэвшсэн.
- Сургалтын хөтөлбөрийн үйл ажиллагааг сурталчлах, хамтын ажиллагааг түгээн дэлгэрүүлэх зорилготой арга хэмжээг жил бүр зохион байгуулж хэвшсэн.
- АУС-ийн цахим хуудсаар болон төгсөгчдийн холбооны фэйсбүүк хуудсаар хөтөлбөрийн талаарх мэдээллийг түгээж, сурталчилдаг.
- Дараах арга хэмжээг жил бүр зохион байгуулж хэвшсэн, тайлан мэдээллийг нэгтгэж, танилцуулдаг:
 - ✓ Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, бусад төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтарсан Нээлттэй өдөрлөг, Нээлттэй хаалганы өдөрлөг
 - ✓ ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад чиглэсэн “Анагаах Ухааны мэргэжил сайхан” сургалт, танилцуулга
 - ✓ Дархан-Уул аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, тус аймагт үйл ажиллагаа явуулдаг их, дээд сургуулиудын консерциум, ерөнхий боловсролын сургуулиудтай хамтарсан “Мэргэжил сурталчлах” өдөрлөг
 - ✓ Төгсөгчдийн “Сайхан сэтгэл” уулзалт
 - ✓ Багш, шавийн уулзалт

Онцлог зүйл:

- Мэргэжил сурталчлах уулзалт, өдөрлөгийг оролцогч талуудыг жигд оролцуулж, зохион байгуулж хэвшсэн.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс дараах сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлага, цахим мэдээлэл гаргасан байна:
 - ✓ “Эх баригч мэргэжилтний цогц чадамж”;
 - ✓ “Биений юмны мөчлөг, түүний хямрал” гарын авлага;
 - ✓ “Эх нярайн цогц тусламж” гарын авлага;
 - ✓ “Эх барих, эмэгтэйчүүдийн практикт түгээмэл тохиолддог өчин, эмгэгийн нэршил, онош зүй” гарын авлага;
 - ✓ “Хүйн ээж 40” ном;
 - ✓ “Оюутны логбүүк”;
 - ✓ АУС-ийн Эрдэм шинжилгээ, мэдээлэл технологийн албанаас сар бүр гаргаж, багш ажиллагсдад түгээдэг “Дархан Анагаах” цахим сонин;
 - ✓ Жил бүр гаргадаг “Сайхан сэтгэл” сэтгүүл (2020-2022 онд цахим хэлбэрээр гаргасан, 2012-2019 онд хэвлэмэл хэлбэрээр гаргасныг цахим хэлбэрт хөрвүүлсэн);
 - ✓ Жил бүр гаргадаг “Дээд боловсрол эрин үе” цахим сэтгүүл (2017-2021 онд хэвлэмэл хэлбэрээр гаргасныг цахим хэлбэрт хөрвүүлсэн);

- ✓ Жил бүр гаргадаг “Эрдмийн чуулган - Багш оюутны эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл” (2020-2022 онд хэвлэмэл хэлбэрээр гаргасны цахим хэлбэрт хөрвүүлсэн);
- ✓ 2021 онд гаргасан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, төлөвшил-III” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.
- АУС-ийн цахим хуудсыг монгол ба англи хэлний хувилбартайгаар 2021 онд шинэчилсэн ба цаг үеийн мэдээлэл, цахим сэтгүүл, товхимлыг тухай бүр оруулж, баяжилт тогтмол хийдэг.

Онцлог зүйл:

- АУС-ийн цахим хуудас, цахим мэдээллийн систем, цахим шууданг хөтөлбөрийн ил тод байдлыг хангахад ашигладаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- 2020 оноос элсэлтийн үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжсэн тул элсэлтийн журам, элсэлттэй холбоотой багц мэдээллийг сургуулийн <https://mnums-da.edu.mn> цахим хуудсын “элсэлт” цэсээс авч, “элсэлт” цэсийн “цахим бүртгэл” хэсэгт хандаж бүртгүүлдэг.
- 2021 оноос БШУЯ-аас гаргасан “Оюутан элсүүлэх журам”-д хими, биологийн 2 хичээлээр хязгаарлахгүйгээр элсэгчдэд боломж бүрдүүлж, хими, биологи, математик, физик, нийгмийн тухай мэдлэг, монгол хэл, англи хэл гэсэн 7 хичээлээс хамгийн өндөр оноотой 2 хичээлийн онооны дарааллаар хяналтын тоонд багтаан элсүүлэхээр болсон.
- Оюутан суралцуулах гэрээ байгуулсанаар оюутны элсэлт баталгааждаг.
- 2022-2023 оны хичээлийн жилд “Эх барихуй” хөтөлбөрөөр элсэгчдийн дундаж оноо 448-460 байгаа нь Боловсрол, шинжлэх ухааны сайдаас баталсан их, дээд сургууль, коллежид бакалаврын зэргийн хөтөлбөрт оюутан элсүүлэх ерөнхий шалгалтын босго оноо 410 байхаар тогтоосон заалтыг хангаж байна.
- Жил бүр шинэ оюутнуудад зориулан “Оюутны хөтөч” гарын авлагыг гаргадаг. Тус хөтөч нь сургалт, хүмүүжлийн ажлын нэгдсэн төлөвлөгөө, мэргэжилтний цогц чадамж, сургалтын төлөвлөгөө, сургууль, алба, тэнхимийн танилцуулга, оюутны тангараг, сургалттай холбоотой дүрэм журмууд, цахим сургалтад хамрагдах зэрэг оюутантай холбоотой бүхий л мэдээлэл, дүрэм журмыг багтаасан байдаг тул шинэ оюутанд арга зүйн зөвлөмжийг цогцоор нь өгдөг.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- АУС нь 300 оюутан хүлээн авах хүчин чадалтай оюутны дотуур байртай. Энэ нь оюутнуудын хэрэгцээг бүрэн хангадаг. Хүсэлт гаргасан оюутан дотуур байранд амьдрах бүрэн боломжтой. 2022-2023 оны хичээлийн жилд 255 оюутан дотуур байранд амьдарсан баримт нотолгоо, бүртгэлтэй танилцлаа. Төлөвлөгөөт их засвар 2023 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлүүлэн хийж байгаатай газар дээр нь биечлэн танилцлаа.
- Дотуур байранд мөрдөх журамтай.
- 2018 оноос оюутнуудын нийгэмшил, төлөвшил, хөгжил, оролцоо, түүний ач холбогдлыг таниулах “Профессорын цаг” сургалтыг тогтмол зохион явуулдаг болсон нь оюутны төлөвшилд ач холбогдолтой байна.
- Оюутнуудад сэтгэл зүйн зөвлөгөө өгөх ажлын хүрээнд мэргэжлийн сэтгэл зүйч ажилладаг. Сэтгэл зүйч нь 2019-2022 онд АУС-ийн болон Дархан-Уул аймагт байршилтай их, дээд, мэргэжлийн сургуулиудын оюутан, багш, ажилчдад 49 удаагийн уулзалт, сургалтыг зохион байгуулж, 69 оюутанд сэтгэл зүйн зөвлөгөө өгсний 9 нь эх барихуйн ангид суралцагч оюутан байна. Ганцаарчилсан болон бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг.
- Анги чиглүүлэх зөвлөх багш ажилладаг. АУС-ийн захирлын 2022 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Зөвлөх багшийн ажиллах журам”-ын дагуу ажилладаг. Зөвлөх багшийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн дагуу оноожуулан үнэлдэг ба ажлын гүйцэтгэлээс хамааран мэргэжлийн үйл ажиллагааны 40 хүртэл оноог тооцдог.
- “Эх барихуй” хөтөлбөрийн оюутнууд зорилтот бүлэг, тусламж үйлчилгээ шаардлагатай хэсэг, нэгжтэй хамтран хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал: Дархан-Уул аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Улаан загалмайн хороо, 7 дугаар цэцэрлэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй эцэг эхийн зөвлөл төрийн бус байгууллага, Ахмад настны үндэсний төвтэй хамтран ажиллаж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгчид болон зорилтот бүлгийн иргэдэд эрүүл мэндийн болон хүмүүнлэгийн тусламж үйлчилгээг тогтмол үзүүлдэг.
- Сүүлийн 5 жилд оюутны эрдэм шинжилгээний хурлыг жил бүр зохион байгуулсан. 2022 оны эрдэм шинжилгээний хуралд Эх барихуйн хөтөлбөрийн оюутнуудаас 3 илтгэл тавьсан байна.

Онцлог зүйл:

- Сэтгэл зүйч нь мэргэжлийн арга, аргачлалыг үйл ажиллагаандаа ашиглахаас гадна судалгаатай ажиллаж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны зөвлөл нь нийт анги, хэсгийн дарга нараас бүрддэг. Урлаг, соёл, хүмүүжлийн баг, эрдэм шинжилгээ, технологийн баг, олон нийт хэвлэлийн баг

болон хөвгүүдийн холбоо, сонирхлын бүлгээс бүрдсэн клубын үйл ажиллагааг чиглүүлж, дэмжин ажилладаг.

- Оюутны мэргэжлийн чиглэл, сонирхолын хүрээнд оюутны сайн дурын 18 клуб үйл ажиллагаа явуулдаг. “Эх барихуй” бакалавр хөтөлбөрөөр суралцагч оюутнуудаас бүрдсэн “Baby” болон “Эх баригч” гэсэн 2 клуб ажилладаг.
- Оюутнуудад суралцах хугацаандаа төсөл бичих, хэрэгжүүлэх ур чадварт сургах, тэдний бүтээлч санал, санаачилгыг дэмжих зорилгоор “Оюутны санаачилга” тэтгэлэгт төслийн уралдааныг 2021 оноос зарлаж, шалгарсан төслүүдийг санхүүжүүлж байна. 2021 онд “Эх барихуй” хөтөлбөрийн 2 дугаар дамжааны оюутнуудын “Цэвэр гар” төсөл шалгарч, 1,700.000 төгрөгийн санхүүжилтийг сургуулийн эрдэм шинжилгээний зардлаас олгосон байна. 2022 онд оюутнуудын дунд явуулсан төслийн уралдаанд “Choice not by change” төсөл шалгарч, 2,687.000 төгрөгийн санхүүжилт авсан байна.
- 2023 оны эрдэм шинжилгээний ажилд 75,793.500 төгрөг төсөвлөсөн байна.
- 2021 онд Оюутны хөдөлмөр эрхлэлтийн төвөөр дамжуулан Ажил олгогч эздийн холбоо, Дархан-Уул аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай байгуулсан Хамтран ажиллах гэрээний хүрээнд 33 байгууллагад 59 оюутан 26,562.730 төгрөгийн ажил хийж гүйцэтгэсэн байна.
- Монгол Улсын Гавьяат эмч, эх барихын ахмад багш Д.Бүрнээгийн нэрэмжит “Шилдэг эх баригч” мэргэжлийн ур чадварын тэмцээнийг 9 жил дараалан зохион байгуулж ирсэн нь мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх, мэргэжлээрээ бахархах боломжийг олгодгоороо давуу талтай юм.
- “Эх барихуй” хөтөлбөрөөр суралцагчдаас сүүлийн 5 жилийн хугацаанд 34 суралцагч 17 сая төгрөгний тэтгэлэгт хамрагдсан байна.

Онцлог зүйл:

- Оюутны зөвлөл нь нийт анги, хэсгийн дарга нараас бүрддэг. Оюутны зөвлөл нь урлаг, соёл хүмүүжлийн баг, эрдэм шинжилгээ, мэдээлэл технологийн баг, олон нийт хэвлэлийн баг болон хөвгүүдийн холбоо, сонирхлын бүлгээс бүрдсэн клубын үйл ажиллагааг чиглүүлж, дэмжин ажилладаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сүүлийн 5 жилд “Эх барихуй” хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнуудаас хөтөлбөр сольж, “Эх барихуй” хөтөлбөрийг сонгосон 4, бусад сургуулиас шилжиж ирсэн 4, жилийн чөлөөнөөс ирсэн 27 оюутан байна.
- Хөтөлбөр хооронд шилжин суралцах оюутан “Багц цаг дүйцүүлэн тооцох журам”-ын дагуу АШУҮИС-ийн Сургалтын бодлого зохицуулалтын газраас дүйцүүлэн тооцуулах журамтай.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- “Эх барихуй” хөтөлбөрийн төгсөлтийн баримт бичгийн загварыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01 дугаар тушаалаар баталсан “Боловсролын баримт бичгийн загвар”-ын дагуу гаргаж, баримтлан ажилладаг.
- АШУҮИС-ийн дүрмийн 4.8.1, 4.8.5 дахь заалт, АУС-ийн Захиргааны зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 21/01 дүгээр хурлын шийдвэрийг үндэслэн гаргасан журмын дагуу олгодог. Төгсөлтийн мэргэжлийн салбар комиссын шийдвэрийг үндэслэн бакалавр болон дипломын зэргийн болзол хангасан төгсөгчдөд АШУҮИС-ийн захирлын тушаалаар мэргэжил, боловсролын зэрэг, диплом, энгэрийн тэмдэг олгодог.
- Сүүлийн 5 жилд “Эх барихуй” хөтөлбөрийн 5 төгсөгч онцгойлох дипломын болзол хангасан байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн сонгон шалгаруулалтыг АШУҮИС-ийн захирлын 2021 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн А/103 дугаар тушаалаар баталсан “Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам”-ыг үндэслэн зохион байгуулдаг. Сонгон шалгаруулах үйл ажиллагааг тэнхим, сургууль, цагийн ачаалалд үндэслэн багшийн хэрэгцээг тодорхойлон нээлттэй зохион байгуулдаг. Мэдээллийг АУС-ийн цахим хуудас болон сонинд байршуулж, нээлттэй зарладаг.
- Мэргэжлийн 5 тэнхим (Суурь шинжлэх ухааны тэнхим, Эм зүй, биоанагаахын тэнхим, Сувилахуйн тэнхим, Эмнэлзүйн тэнхим, Нийгмийн эрүүл мэнд, уламжлалт анагаах ухааны тэнхим) үйл ажиллагаа явуулдаг.
- Багш нарын 13.8% нь доктор, 83.2% магистр зэрэгтэй, эх барихуйн үндсэн мэргэжлийн 4 багшаас 2 нь АШУҮИС-д, 1 нь МУБИС-ийн докторантурын сургалтад суралцаж байна.
- Багш, суралцагчдын тооны харьцаа оновчтой 1:17. Эх барихуйн хөтөлбөрөөр 2022-2023 оны хичээлийн жилд 1-р дамжаанд-36, 2-р дамжаанд-36, 3-р дамжаанд 4, 4-р дамжаанд-2 нийт 80 оюутан суралцаж байна.
- Мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлийн 24 багш нарын 16.6% нь ахлах зэрэгтэй.
- Багшийн хөгжлийн дэд хөтөлбөрийг АУС-ийн захирлын 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар баталсан бөгөөд уг хөтөлбөрийн 2.1, 2.2 заалтын дагуу шилдэг хүний нөөцийг бүрдүүлж, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, багшийн эрдэм шинжилгээ, судалгааны ур чадварыг хөгжүүлэхэд сургалтын ачааллын хөнгөлөлт, доктор багшийн нэмэгдэл, шилдэг тэнхим, багш, ажлын хэсэг, ажилтан зэргийг шалгаруулж жил бүр урамшуулдаг.

- Судлаачдад дэмжлэг үзүүлэх тухай урамшууллыг санаачлан хэрэгжүүлж ИФ өндөртэй сэтгүүлийн ранкад үндэслэн урамшуулал олгож одоогоор 1 багшид олгосон байна.

Онцлог зүйл

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нийт 36 багш 100 хувь үндсэн багшаар ажиллаж, сургалтыг зохион байгуулж байгаа нь хөтөлбөрийн хүний нөөцийн давуу тал болж байна.
- Ажилласан жилийн үзүүлэлтээр 20-ээс дээш ажилласан багш нар 38.8% эзэлж байгаа нь багшийн туршлага өндөр байгааг харуулж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн “Багшийн хөгжлийн хөтөлбөр”-ийг бусад төрийн өмчийн 6 сургуультай зөвшилцөн АШУҮИС-ийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/259 дугаар тушаалаар баталж, 4 жилийн хугацаатай батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд Заах ба суралцахуй, Эрдэм шинжилгээ судалгаа, Мэргэжлийн болон нийгмийн үйл ажиллагаа, Хувь хүний хөгжил гэсэн үндсэн 4 чиглэлтэй, үүний дагуу календарчилсан төлөвлөгөөний хүрээнд багшийн хөгжлийн ажлын хэсэг нарийвчилсан төлөвлөгөөг гарган хэрэгжүүлдэг.
- Хувь хүний хөгжлийн төлөвлөгөөг багш бүр боловсруулж, гүйцэтгэлийг харьяалах тэнхимд танилцуулан хэлэлцүүлдэг. Гүйцэтгэлээр шалгарсан багш нарыг мэргэжлийн тэнхим бүрээс, төлөөллийн багш нар болон удирдлага, сургалтын албаны хамтарсан баг хэлэлцэж, шилдэг багш, шилдэг залуу багш тус тус жилд 1 удаа шалгаруулан, 1 удаагийн урамшуулал олгож, бусад багш нарт сайн туршлагыг танилцуулдаг.
- Багш бүр өөрийгөө хөгжүүлэх “Багшийн хөгжлийн зураглал”-ын дагуу “Хувь хүний хөгжлийн төлөвлөгөө”-г 3 үндсэн хэсгээр боловсруулан тэнхимийн эрхлэгчээр батлуулан хэрэгжүүлдэг:
 - ✓ Сургалтын үйл ажиллагааг 12 асуултаар
 - ✓ Эрдэм шинжилгээний үйл ажиллагааг 12 асуултаар
 - ✓ Мэргэжлийн үйл ажиллагааг-10 асуултаар, нийт 34 асуулга бүхий шалгуураар өөрийн үнэлгээг хийдэг.
- 2022-2023 оны хичээлийн жилд АШУҮИС-ийн Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд “Модуль-1-сургалтын технологийн дэвшил”, “Модуль-2-судалгааны арга зүй ба бүтээл хэвлүүлэх” 4 багц цагийн сургалтад багш нарыг 100% хамруулж, гэрчилгээ олгосон.
- Багш солилцоо хөтөлбөрөөр Франц улсын Мулан хотын Улаан загалмайн дэргэдэх сувилахуйн сургуулиудын хамтын ажиллагааны хүрээнд 4 багш туршлага судалсан.

Онцлог зүйл:

- АШУҮИС-ийн Багшийн хөгжил, цахим сургалтын төв нь багш нараас судалгааг 2 жилд 1 удаа авч, төлөвлөгөө гаргасны үндсэн дээр нээлттэйгээр цахим болон танхимын хосолсон хэлбэрээр сургалтууд зохион байгуулдаг.
- Цахим хичээл, аудио хичээл бэлтгэх өрөөг тохижуулж, багш нарын хөгжих боломжийг дэмжин ажиллаж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Эрдэм шинжилгээ, судалгаа хариуцсан ажлын хэсэг нь үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, судалгааны сэдэв сонголт, судалгааны төсөл, судалгааны статистик боловсруулалт, судалгааны өгүүлэл бичих багц цагийн сургалтыг АУС-ийн хэмжээнд зохион байгуулдаг.
- 2021 онд 2.680.000 төгрөгийн санхүүжилттэй “Цэвэр гар” төслийг 2 багш, 4 оюутны бүрэлдэхүүнтэй баг хэрэгжүүлж, 5 зөвлөгөө мэдээлэл хүргэж, гарыг зөв угаах дадал эзэмшүүлэх уралдаан зохион байгуулж, гар халдваргүйжүүлэх сургалтыг 3 удаа зохион байгуулсан.
- Францын Мулан хотын Улаан загалмайн сувилахуйн сургуультай хамтран хэрэгжүүлсэн багш, оюутан солилцооны хөтөлбөрийн хүрээнд 2018 онд 4 багш, 2019 онд 2 багш, 2022 онд 4 багш, 2 оюутан, 2023 онд 2 багш, 2 оюутан туршлага судалсан.
- Люксембургийн Засгийн газар, НҮБ-ын Хүн амын сан, Монгол Улсын Засгийн газраас хамтран хэрэгжүүлсэн “Эх нярайн тусламжид зайн оношилгооны дэмжлэг үзүүлэх” төслийн санхүүжилтээр “Эх барихуй” хөтөлбөрт үнэлгээ хийж, үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хөтөлбөрийн дагуу оюутны хөтөч хэвлэн гаргахад АУС-ийн багш нар хамтран оролцсон.
- Японы Доккио АУС, Эх барихуйн салбар судалгааны төвтэй хамтран “Төрөх үеийн эх барихын тусламж, үйлчилгээний өнөөгийн байдал” судалгааны төслийг 2023 онд эхлүүлсэн.
- Сүүлийн 5 жилд хэвлэн нийтлүүлсэн өгүүлэл дотоодод 110, гадаадад 16, хэлэлцүүлсэн илтгэл 98, дотоод, гадаадад хэлэлцүүлсэн илтгэл 80, Олон улсын IF-тай сэтгүүлд нийтлэгдсэн өгүүллийн тоо 2 байна.
- Сургууль хөгжүүлэх “Стратеги төлөвлөгөө 2018-2024” бодлогын баримт бичигт заасны дагуу эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулах төсөв жил бүр нэмэгдүүлэн тусгаж, зарцуулсан байна: 2018 онд 950.000, 2019 онд 1.5 сая, 2020 онд 3 сая, 2021 онд 3.5 са, 2022 онд 4 сая, 2023 онд 4.5 сая төгрөг.

Онцлог зүйл:

- Олон улсын болон сургуулийн эрдэм шинжилгээний хурлыг тогтмол зохион байгуулдаг.
- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийг 2012 оноос “Сайн санаа-Сайхан санаа”, 2017 оноос “Дээд боловсрол-Эрин үе” сэтгүүл байдлаар гаргаж, олны хүртээл болгож байна. 2021 онд “Дээд боловсрол-Эрин үе” сэтгүүл олон улсын ISSN2789-8946 дугаартай болсон ба жилд 2 дугаар эрхлэн гаргаж байна.
- 2017 онд Франц Улсын Санте Сюд төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр “Эх баригчийн мэргэжил, ур чадварыг бэхжүүлэх” төсөлд хамтран ажиллаж, төслийн хүрээнд эх барих, эмэгтэйчүүд судлалын 3 багш сургагч багшаар бэлтгэгдэж, төгсөлтийн өмнөх сургалтын хөтөлбөрийг сайжруулах, төгсөлтийн дараах багц цагийн сургалт, сургалтын хөтөлбөрийн агуулгыг шинэчлэхэд багаар ажилласан.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн захирлын 2021 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн А/103 дугаар тушаалаар баталсан “Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам”-ын дагуу багшийн ажлын хөндлөнгийн үнэлгээг 3 жилд 1 удаа, ахлах болон түүнээс дээш зэрэгтэй багш нар 5 жилд 1 удаа хийж, хөдөлмөрийн гэрээ сунгах болон зэрэг ахих боломжийг олгодог.
- Албан тушаалын зэрэглэлээс хамааран сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа гэсэн 3 чиглэлээр төлөвлөгөөг гаргаж, тайлангаа бичдэг ба шалгуур хуудсаар өөрийгөө үнэлгээг хийж, үнэлгээний үндэслэл, тайлбарыг дэлгэрэнгүй тусгадаг.
- АШУҮИС-ийн Багшийн хөгжил, цахим сургалтын газраас хөндлөнгийн үнэлгээг хийж багшийн зэрэглэлийг тогтоодог. Багшийн ажлын өөрийн үнэлгээ 70 оноо, үлдсэн 30 оноог тэнхимийн эрхлэгч үнэлгээний хуудсын дагуу хөндлөнгөөс үнэлдэг.
- Үнэлгээ хийлгэх багш нарт мэдээллийг урьдчилан өгдөг ба багш бүрт АШУҮИС-ийн Багшийн хөгжил, цахим сургалтын газрын арга зүйч, АУС-ийн арга зүйч зөвлөн тусалдаг.
- Багшийн ажлын хавтсыг 100 хувь цахимжуулж, программд албан тушаалын зэрэглэлээс хамааран үндсэн хэсэг, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа, шагнал урамшуулал, хичээлийн файлын бүрдэлт чиглэлээр сургалт, ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл болон нотлох баримтыг файл хэлбэрт оруулж байршуулдаг.

Онцлог зүйл:

- Багшийн үнэлгээг сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа, тэнхимийн эрхлэгчийн үнэлгээ, оюутны үнэлгээ гэсэн 5 чиглэлээр 100 хувьд дүйцүүлэн үнэлдэг.
- Суралцагч багшийг цахимаар хөндлөнгөөс үнэлдэг.
- Удирдлага болон зөвлөлийн үнэлгээнд дадлагажигч багш 1 жилд 1 удаа, багш 3 жилд 1 удаа, ахлах болон түүнээс дээш зэрэгтэй багш нар 5 жилд 1 удаа багшийн үнэлгээний журмаар хөндлөнгөөс үнэлүүлж, хөдөлмөрийн гэрээ сунгах болон зэрэг ахих боломжийг олгодог.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн Удирдах зөвлөл, Боловсрол хариуцсан дэд захирал, Төгсөлтийн өмнөх сургалтын бодлого зохицуулалтын газар, Хөтөлбөрийн ерөнхий хороо, салбар Анагаах ухааны сургууль, Хөтөлбөрийн дэд хороо, Тэнхим, Чанарын хороо, Дотоод аудитын баг, Сургалтын алба гэсэн удирдлага, зохион байгуулалтаар ажилладаг. Хөтөлбөрийн дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схемтэй.
- АШУҮИС-ийн захирлын 2022 оны А/225 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг зохицуулах журам”, 2019 оны 1 дүгээр сарын 28-ны А/19 дүгээр тушаалаар баталсан “Сургалтын технологи, чанарын хяналтын үлгэрчилсэн журам”, “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хэрэгжүүлж ажилладаг.
- Чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015 стандартыг 2017 оноос хэрэгжүүлж байна. Чанарын менежментийн тогтолцооны гарын авлагыг боловсруулж, АУС-ийн захирлын зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн, Чанарын хорооны 2017 оны 10 дугаар сарын 09-ний хурлаар хэлэлцэж баталсан.
- Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO14001:2015 стандартыг 2018 оноос хэрэгжүүлж байна. Байгаль орчны менежментийн тогтолцооны гарын авлагыг боловсруулж, АУС-ийн захирлын зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн, Чанарын хорооны 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хурлаар хэлэлцэж баталсан.
- АУС-ийн захирлын 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн А/15 дугаар тушаалаар Чанарын нэгдүгээр баг буюу дотоод аудитын багийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталж хэрэгжүүлж байна. Сургалтын үйл ажиллагаа, элсэлтийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт жил тутам хийж, тайлагнадаг. Төгсөх ангийн оюутны баримт бичиг, дүнгийн үнэлгээнд хяналт-шалгалт жил тутам хийж, зөрчил арилгуулдаг.
- Сургуулийн захирлын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/87 дугаар тушаалаар Хөтөлбөрийн дэд хорооны үйл ажиллагааг зохицуулах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан байна. Хөтөлбөрийн дэд хороо нийт 15 гишүүнтэй бөгөөд дэд хорооны даргаар сургуулийн захирал, нарийн бичгийн даргаар сургуулийн Сургалтын албаны дарга, гишүүдээр тэнхимийн багш нар болон оюутан, ажил олгогчдын төлөөлөл ажилладаг.
- Эх барихуйн бакалаврын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх хүрээнд нийт 5 удаа явцын хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. Үүнд: Анагаах ухааны сургуулийн Хөтөлбөрийн дэд хорооны хурлаар 3 удаа, Захиргааны зөвлөлийн хурлаар 2 удаа танилцуулж, санал авч, тусгасан байна.
- Сургалтын алба жил бүр оюутны сэтгэл ханамжийн судалгааг сургалтын үйл ажиллагаа, багшийн үйл ажиллагаа, сургалтын орчин, оюутны үйл ажиллагаа гэсэн 4 үзүүлэлтээр хийж, нэгтгэн дүгнэдэг. Төгсөгч, ажил олгогчдоос жил бүр сэтгэл ханамжийн судалгааг авч хэвшсэн.
- ЭМЯ-ны харьяа ЭМХТ-өөс жил бүр зохион байгуулдаг эх барих үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад төгсөгчид 100 хувийн амжилттай өгч, тэнцдэг.

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийн явцын хэлэлцүүлэг, хурлын тэмдэглэл, шийдвэрийг тухай бүр хөтөлж, баталгаажуулж, нэгтгэж хадгалсан.
- Чанарын менежментийн тогтолцооны гарын авлагыг АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн чанарын менежер болон зөвлөх компанийн дэмжлэгтэйгээр багш нарын оролцоог хангаж боловсруулж, үйл ажиллагаандаа ашиглаж хэвшсэн.
- Байгаль орчны менежментийн тогтолцооны гарын авлагыг мөн боловсруулж, ашигладаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Сургуулийн зүгээс 2017 оноос эхлэн Дархан-Анагаах төгсөгчдийн холбоогоор дамжуулан төгсөгчдийн мөшгих судалгаа, ажил олгогчдын судалгааг тогтмол хийж, дүгнэж хэвшсэн байна. Тухайлбал сүүлийн 4 жилийн хугацаанд Эх баригч мэргэжлээр төгссөн 157 төгсөгчөөс 153 (97.5%) нь судалгаанд хамрагдсан байх бөгөөд төгсөгчдийн 99 (64.7%) нь эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ ажиллаж байна. Эх баригч мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгчдийн 95 (62%) нь эрхэлж буй ажилтай нь эзэмшсэн мэргэжил маш их холбоотой гэж хариулсан байна.
- Төгсөгчдийн холбооноос хийсэн судалгаагаар тус сургуулийг төгссөн эх баригч нараас “Зөвлөх” зэрэгтэй эх баригч 1, “Тэргүүлэх” зэрэгтэй эх баригч 9, ахлах зэрэгтэй эх баригч 14 байна.
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаанаас харахад төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэл хүлээсэн хугацаа нь 2018 онд 3.8 ± 3.34 сар, 2019 онд 2.58 ± 1.58 , 2020 онд 2.35 ± 1.58 сар, 2021 онд 2.50 ± 2.93 сар байсан буюу хүлээсэн хугацаа нь 4 жилийн хугацаанд 1.3 сараар буурсан байна.
- Төгсөгчдийг үнэлсэн сонирхогч талуудын сэтгэл ханамжийн үнэлгээний тайланг 2017.10.27, 2018.05.25, 2019.11.25, 2020.10.30, 2022.05.25-нд, төгсөгчдийн мөшгих судалгааны тайланг 2018.05.25, 2019.11.24, 2020.11.12, 2021.12.27, 2022.06.30-нд тус тус нэгтгэн гаргасан байна.
- Боловсролын үйлчилгээний талаарх ажил олгогчдын сэтгэл ханамжийг 2018-2021 онд Ликертийн хэмжүүрээр үнэлэхэд 2018 онд 2.53 байсан бол 2019 оноос сайн гэж үнэлэгдэх болсон байна: 2019 онд 3.91 ± 0.88 , 2020 онд 3.95 ± 0.5 , 2021 онд 3.94 ± 0.6 .
- Ажил олгогчдын 2022 оны судалгаагаар эх баригч мэргэжлээр төгсөгчдийн бие даан ажиллах чадварт 80.2, багаар ажиллах чадварт 82.5, бичих чадварт 75.6, ярианы чадварт 80.2, багаар ажиллах чадварт 82.5, бичих чадварт 75.6, ярианы ур чадварт 80, тухайн ажил мэргэжлийн мэдлэгт 75.6 нь сэтгэл ханамжтай, маш ханамжтай гэсэн үнэлгээ өгсөн байна.
- Төгсөгчдийн ажил эрхлэлт, сэтгэл ханамжийн талаарх судалгааг жил тутам давтамжтайгаар авч, дүн шинжилгээ хийж үйл ажиллагаандаа тусган ажилладаг. 2018-2021 онд Эх барихуй хөтөлбөрөөр төгссөн 153 төгсөгчөөс судалгаа авахад 99 (64.7%) нь эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ ажиллаж байна.

Онцлог зүйл:

- Төгсөгчдийн мэргэжлээрээ ажил эрхлэлтийн хувь сайн;
- Эх баригчийн цогц чадамж боловсруулж, сургалтын үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн гадаад хэлний мэдлэгийг сайжруулах хүрээнд англи хэлний кредит цагийг нэмэгдүүлэх боломжийг судлах шаардлага байна. Шинжээчдийн багийнхан төгсөгчид, оюутнууд, ажил олгогчидтой хийсэн ярилцлагын үеэр энэ талаар саналууд гарсан.

Зөвлөмж:

- Оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдах боломжийг нэмэгдүүлэх, төгсөгчдийн карьер өсөлтийг дэмжих үүднээс англи хэлийг 1 дүгээр дамжаанаас гадна 2-3 дугаар дамжаанд орох боломжийг судлах.

Үнэлгээ: Бүрэн хангасан.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- АУС нь 2022, 2007, 2018 онд Байгууллагын магадлан итгэмжлэлд хүсэлт гаргаж, магадлуулсан.
- “Эх барихуй” хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх хүсэлт анх удаа гаргасан.
- Боловсролын сайдын 2022 оны 5 дугаар сарын 09-ний А/160 дугаар тушаалын дагуу Эх барихуй хөтөлбөр нь диплом, бакалавр, магистр, докторын зэрэгтэй бэлтгэх мэргэжлийн чиглэл, индекстэй.
- Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 15-ны А/513 дугаар тушаалаар баталсан “Мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөс баталсан “Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох чиглэл” (Тус зөвлөлийн 2020 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан 2020-2022 оны мэргэжил/мэргэшлийн чиглэлийн дагуу эх баригч анх удаа зөвлөх зэрэг хамгаалах боломжтой болсон, тус зөвлөлийн 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан 2023-2025 оны мэргэжил/мэргэшлийн чиглэлийн дагуу эх баригчид ахлах, тэргүүлэх, зөвлөх зэрэг үргэлжлүүлэн олгоно), Монголын эх баригчдын нийгэмлэгээс баталсан тусгай шалгуурын дагуу эх баригчид ахлах, тэргүүлэх, зөвлөх зэрэг олгодог.
- Зөвшөөрлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу эх баригч нь эх барих үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэйгээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг.
- Эх барихуй хөтөлбөрийн багш нар Эх барих, эмэгтэйчүүдийн эмч нарын холбоо, Монголын сувилагчдын нийгэмлэгтэй хамтран ажилладаг, гишүүнчлэлтэй байдаг. Тус сургуулийн хүний нөөцийн ажилтны гаргасан судалгаагаар 44 багш ажиллаж байгаагаас Эх барих, эмэгтэйчүүдийн эмч нарын холбооны гишүүн 2, Сувилахуйн нийгэмлэгийн гишүүн 6 байгаа бөгөөд бусад багш нар өөрийн мэргэжил, ажлын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн холбооны гишүүнчлэлтэй. Тухайлбал Монголын хүүхдийн эмч нарын нийгэмлэг, Эм судлаач багш нарын нийгэмлэг, Дотрын өвчин судлалын эмч нарын нийгэмлэг, Эм холбоо, Неврологийн нийгэмлэг, Англи хэлний багш нарын холбоо гэх мэт.
- Дархан-Анагаах төгсөгчдийн холбоотой хамтран ажилладаг. Тус холбоо нь нийт 10 салбартай (Өвөрхангай, Орхон, Булган, Хөвсгөл, Дундговь, Баянхонгор, Архангай, Увс, Дорнод, Улаанбаатар) бөгөөд Дархан-Уул аймагт ажиллаж байгаа 26 эх баригч Монголын эх баригчдын нийгэмлэгийн гишүүнчлэлтэй гэсэн судалгаатай.

- Эрүүл мэндийн сайдын 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн А/445 дугаар тушаалаар баталсан “Төгсөлтийн дараах үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс”-ийн дагуу жирэмслэлтэд бэлтгэх зөвлөгөө, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн зөвлөгөө, жирэмсэн ба төрсний дараах үеийн зөвлөгөө, хөхөөр хооллолтын зөвлөгөө, гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөө гэсэн 5 чиглэлээр төрөлжиж суралцах боломжтой болсон. Тус 5 чиглэлийн төрөлжсөн мэргэшлийн сургалтад 2023 оны 4 дүгээр сараас эхлэн нийт 23 эх баригч АШУУИС-ийн Мэргэжил дээшлүүлэх институтэд анх удаа элсэн суралцаж байгаагийн 6 нь тус АУС-ийг төгсөгч байна: Жирэмслэлтэд бэлтгэх зөвлөгөө (сургалтын индекс - S(s) 0913-00-28) сургалтад 1, Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн зөвлөгөө (сургалтын индекс - S(s) 0913-00-29) сургалтад 1, Жирэмсэн ба төрсний дараах үеийн зөвлөгөө (сургалтын индекс - S(s) 0913-00-30) сургалтад 1, Хөхөөр хооллолтын зөвлөгөө (сургалтын индекс - S(s) 0913-00-30) сургалтад 2, Гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөө (сургалтын индекс - S(s) 0913-00-30) сургалтад 1 төгсөгч тус тус суралцаж байна.
- 2018-2021 онд эх баригчаар төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаанд хамрагдсан 153 төгсөгчийн 16 (10.5%) дахин суралцсан гэсэн мэдээлэлтэй.
- 2017-2019 оны АУС төгсөгчдийн мөшгих судалгааны дүнгээс харахад төгсөөд дахин суралцсан эсхүл дахин суралцана гэж хариулсан төгсөгчдийн эзлэх хувь 2017 онд 27.9%, 2018 онд 37.2%, 2019 онд 43.7 хувь болж нэмэгдсэн байна.

Онцлог зүйл:

- Дотоод, гадаадын их, дээд сургуулиудтай хамтын ажиллагаа сайн, үйл ажиллагаа тогтвортой.

Анхаарах асуудал:

- Монголын эх баригчдын нийгэмлэгтэй хамтран ажиллах, үйл ажиллагааг уялдуулахад анхаарах.

Зөвлөмж:

- Монголын эх баригчдын нийгэмлэг ба Дархан-Анагаах төгсөгчдийн холбооны хамтын үйл ажиллагааг нэмэгдүүлж, мэдээлэл харилцан солилцох талаар санаачилгатай ажиллах;
- Төгсөгчдийн судалгааны маягтад мэргэжлийн холбооны гишүүнчлэл, төгсөлтийн дараах сургалтын талаар нэмж оруулж, мэдээллийг жил бүр шинэчлэх.

Үнэлгээ: Бүрэн хангасан

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгч лэн ханга сан (1)	Хангаа гүй (0)	Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			
2	Сургалтын үйл ажиллагаа	3			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх	3			
4	Хөтөлбөрийн удирдлага,	5			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5			
6	Багшийн үйл ажиллагаа	4			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	3			
	Нийт	26			
Дүгнэлт		Бүрэн хангасан			

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар АУС
Хөтөлбөрийн нэр	“Эх барихуй” бакалаврын хөтөлбөр
Хөтөлбөрийн индекс	091308
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	- Сургалтын хэрэглэгдэхүүнийг шинэчлэлийг технологийн хурдацтай зэрэгцүүлэн хийж ур чадварын төвийг өргөжүүлэх - Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг судлах
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	- Сургалтын төлөвлөгөөнд англи хэлний хичээлийн багц цагийг нэмэгдүүлэх, англи хэлийг давтамжтайгаар тасралтгүй суралцах сургалтыг зохион байгуулах - Ажил олгогч байгууллага, төгсөгчдөөс зөөлөн ур чадварыг тодруулсан асуумж судалгааг авах - Эх барихуйн мэргэшүүлэх хичээлд давтамжтай хэрэглэдэг онцлог сургалтын аргуудыг суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагатай харьцуулсан судалгааг хийж хөтөлбөрийн төгсгөлд хүрэх үр дүнг тооцдог байх.
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	- Сүүлийн үеийн төрөлтийн симуляторыг худалдаж авах талаар бичсэн төслөө идэвхжүүлж, хэрэгжүүлэх
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	- Оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдах боломжийг нэмэгдүүлэх, төгсөгчдийн карьер өсөлтийг дэмжих үүднээс англи хэлийг 1 дүгээр дамжаанаас гадна 2-3 дугаар дамжаанд үргэлжлүүлэн орох боломжийг судлах - Монголын эх баригчдын нийгэмлэг ба Дархан-Анагаах төгсөгчдийн холбооны хамтын үйл ажиллагааг нэмэгдүүлж, мэдээлэл харилцан солилцох талаар санаачилгатай ажиллах. - Төгсөгчдийн судалгааны маягтад мэргэжлийн холбооны гишүүнчлэл, төгсөлтийн дараах сургалтын талаар нэмж оруулж, мэдээллийг жил бүр шинэчлэх
ШААРДЛАГА: /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал шаардлага бичнэ/	
	-

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургуулийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны сургуулийн “Эх барихуй” бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “Бүрэн хангасан” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрүүл мэндийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг Д.Баярмаа

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Н.Мөнгөнсор

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... С.Баясгалан

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

4.1 Эх барихуй хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутны төлөөлөл

Огноо: 2023.05.29-ны 14.00 цаг

Хаана: хичээлийн А байр, эрдмийн өргөө №201

№	Оюутны овог нэр	Дамжаа	Харьяалал	Утас
1	Б.Сосорбарам	ЭБ 4	Орхон аймаг	85884888
2	Б.Адъяадолгор	ЭБ 4	Өвөрхангай аймаг	88855346
3	Б.Маралгуа	ЭБ 4	Булган аймаг	95620888
4	О.Оюун-Эрдэнэ	ЭБ 3	Сэлэнгэ аймаг	85937958
5	Ю. Урангоо	ЭБ 3	Дархан-Уул аймаг	99376851
6	Б.Мягмарчулуун	ЭБ 3	Хөвсгөл аймаг	99958706
7	Д.Цагаанцэцэг	ЭБ 3	Дархан-Уул аймаг	95233674
8	Б.Мөнхжаргал	ЭБ 2	Хөвсгөл аймаг	89428992
9	Х.Азжаргал	ЭБ 2	Сэлэнгэ аймаг	99654751
10	О.Алтанминж	ЭБ 2	Дархан аймаг	95392883
11	С.Оюун-Эрдэнэ	ЭБ 2	Орхон аймаг	99755978
12	Б.Энхцэцэг	ЭБ 2	Булган аймаг	85648443
13	Д.Хонгорзул	ЭБ 2	Орхон аймаг	99880169
14	Б.Цасчихэр	ЭБ 2	Дархан-Уул аймаг	95658224
15	Х.Номин	ЭБ 2	Дархан-Уул аймаг	99750950
16	Э.Нарангарав	ЭБ 2	Сэлэнгэ аймаг	
17	Г.Мөнхчимэг	ЭБ 1	Сэлэнгэ аймаг	91244049
18	Б.Сүндэрьяа	ЭБ 1	Хөвсгөл аймаг	80970626
19	Г.Алимаа	ЭБ 1	Орхон аймаг	80909536
20	Н.Чанцалням	ЭБ 1	Өвөрхангай аймаг	86281999
21	С.Хулан	ЭБ 1	Орхон аймаг	99880463
22	Б.Мөнхцэцэг	ЭБ 1	Дархан-уул аймаг	99771660
23	Г.Хоролсүрэн	ЭБ 1	Орхон аймаг	80369786
24	Т.Цэцэгзул	ЭБ 1	Дархан-уул аймаг	99674939
25	Г.Санжидмаа	ЭБ 1	Өвөрхангай аймаг	91899599
26	О.Цэцэн	ЭБ 1	Орхон аймаг	94709919
27	Ц.Оюун-Эрдэнэ	ЭБ 1	Дархан-уул аймаг	90379922 96376664
28	Ш.Үүрийнцолмон	ЭБ 1	Сэлэнгэ аймаг	99880571
29	Г.Ариунболор	ЭБ 1	Дархан-уул аймаг	89705321
30	Б.Ганболор	ЭБ 1	Дархан-уул аймаг	99317424
31	Э. Байгальмаа	ЭБ 1	Сэлэнгэ аймаг	94372440
32	О.Анударь	ЭБ 1	Улаанбаатар хот	89010156
33	Ш.Даяндорж	ЭБ 1	Улаанбаатар хот	80187664

4.2 Эх барихуй хөтөлбөрт оролцогч багш нарын төлөөлөл

Огноо: 2023.05.29-ны 16.00 цаг

Хаана: хичээлийн А байр, эрдмийн өргөө №201

№	Багшийн овог нэр	Албан тушаалын зэрэг	Заадаг хичээл	Утас
1.	Ж.Номин-Эрдэнэ	Эмнэлгийн хөгжлийн албаны дарга	Перинаталь судлал	99151797
2.	Б.Мэндхүү	Дэд профессор багш	Анатоми	99700232
3.	П.Дуламжав	Ахлах багш	Хүүхдийн өвчний цогц менежмент, хүүхэд, нярай судлал	99757735
4.	П.Нямсүрэн	Ахлах багш	Дотрын өвчин	99129358
5.	Ц.Эрдмаа	Ахлах багш	Эх барихуй, харилцааны ур чадвар	99068169
6.	Д.Нямаажав	Ахлах багш	Анагаах ухааны ёс зүй, хүүхэд, нярай судлал	
7.	Л.Нарантуяа	Ахлах багш	Монгол хэл, бичиг, найруулга зүй	99378596
8.	Х.Оюунгэрэл	Ахлах багш	Эм судлал	99394839
9.	Ц.Болормаа	Ахлах багш	Анагаахын хими	94388868
10.	Н.Баярмаа	Ахлах багш	Мэргэжлийн англи хэл	99163679
11.	Х.Мөнхчулуун	Багш	Эх барихуй	99776011
12.	М.Ариунболор	Багш	Эрүүл мэндийн үнэлгээ, нүд, чих, хамар хоолой	80274444
13.	Б.Тунгалаг	Дадлагажигч багш	Дотрын өвчин, эрүүл мэндийн үнэлгээ	99281772
14.	А.Батгэрэл	Дадлагажигч багш	Ерөнхий мэс засал, мэс заслын өвчин	88091252
15.	А.Мөнх-Эрдэнэ	Гэрээт багш	Мэс заслын сувилахуй, мэс заслын өвчин	80380712

4.3 Эх барихуй хөтөлбөрөөр төгсөгчдийн төлөөлөл

Огноо: 2023.05.30-ны 10.00-11.00 цаг

Хаана: Цахим уулзалт

<https://us06web.zoom.us/j/82390403091?pwd=ekVOUkxnajd5WmJ1elpBRExVBFNuZz09>

Meeting ID: 823 9040 3091

Passcode: 462063

№	Төгсөгчийн нэр	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	Утас
1.	Цэндсүрэн	2018	“Амин холбоо” ерхийн эрүүл мэндийн төв, эх баригч	99943024
2.	Дэлгэрцэцэг	2020	Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг, Төрөх тасгийн эх баригч	99586430

3.	Хулан	2020	Өрхийн эрүүл мэндийн төв, эх баригч	88185680
4.	Суванна	2020	Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг, Төрөх тасгийн эх баригч	99128340
5.	Жавзанпагма	2021	Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг, Төрөх тасгийн эх баригч	85386404
6.	Нарангэрэл	2021	Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг, Төрөх тасгийн эх баригч	94385992
7.	Ц.Долгорсүрэн	2021	Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлэг, эх баригч	95371411
8.	С.Оюунтунгалаг	2019	Орхон аймгийн өрхийн эрүүл мэндийн төв, эх баригч	99324669
9.	Бахатгүль	2021	“Гурван гал” эмнэлэг, эх баригч	85808471
10.	П.Одсүрэн	2020	Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийг дэмжих төв, эх баригч	86329093 95244093
11.	М.Намуунбайгаль	2020	Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг, эх баригч	88360886
12.	Нямгэрэл	2019	Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг, эх баригч	89502435
13.	Анхцэцэг	2020	Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг, эх баригч	89481516
14.	Төрболд	2018	Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг, эх баригч	99504516
15.	Чимэднамжил	2018	Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг, эх баригч	80620004
16.	А.Сэржмаа	2019	Амгалан амаржих газар-төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, эх баригч	99334906
17.	Б.Пүрэвсамбуу	2019	Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II, эх баригч	86585854 99447545
18.	Б.Энхмаа	2020	Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын эрүүл мэндийн төв, эх баригч	99383702
19.	Х.Ууганболор	2021	Интермед эмнэлэг, эх баригч	99647159
20.	Н.Мөнхзул	2021	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, эх баригч	89354494
21.	Н.Номин-Эрдэнэ	2022	Хүрээ амаржих газар-төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, эх баригч	89870221

4.4 Эх барихуй хөтөлбөрөөр төгсөгчдийн ажил олгогчдын төлөөлөл

Огноо: 2023.05.30-ны 11.00-12.00 цаг

Хаана: Цахим уулзалт

<https://us06web.zoom.us/j/89284893034?pwd=azlQTXNYY1RIUGVNS0cxcVdsbEhOUT09>

Meeting ID: 892 8489 3034

Passcode: 310861

№	Ажил олгогчийн овог, нэр	Байгууллага, албан тушаал	Утас
1.	Б. Мөнхбат	Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлгийн Ерөнхий эмч	99089398
2.	А.Оюун-Эрдэнэ	Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлгийн Сувилахуйн албаны дарга	99404504
3.	Ц.Эрдэнэчимэг	Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлгийн дарга	99034645
4.	Б. Мөнхцацрал	Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлгийн Сувилахуйн албаны дарга	99035994
5.	Д.Рэнчиндулам	Эх барих эмэгтэйчүүдийн клиникийн эрхлэгч	99021092
6.	Д.Болормаа	Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал	88078825
7.	П.Оюун-Эрдэнэ	Булган аймгийн нэгдсэн эмнэлгийн Амаржих тасгийн эмч	99724409
8.	Батсайхан	Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга	99992302

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/



АШУУИС
1942

АШУУИС-ИЙН ДАРХАН-УУЛ АЙМАГ САЛБАР АНАГААХ УХААНЫ СУРГУУЛЬ

13 дугаар баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45051

Утас: 70377734

Цахим нууцдан: darhanuul@mnums.edu.mn


2023.06.19 № 023
танай _____-ны № _____-т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛД

Хүсэлт гаргах тухай

Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн ажлын албаны захирлын 2023 оны А/140 тоот тушаалаар томилогдсон шинжээчийн баг тус сургууль дээр 2023 оны 05 дугаар сарын 29,30-ны өдрүүдэд ажиллаж “Эх барихуй” 091308 бакалаврын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан, шалгуурын дагуу илрэл, нотлох баримттай танилцаж хөндлөнгийн үнэлгээ хийсэн болно. Шинжээчийн хөндлөнгийн үнэлгээний тайланг 2023 оны 06 дугаар сарын 14-ны өдөр хүлээн авч хөндлөнгийн шинжээчийн тайлантай танилцаж бид хүлээн зөвшөөрч байна.

ЗАХИРАЛ



Б.БАЯСГАЛАНМӨНХ

A4_2023 он.docx